

**ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙСЭН ТАЛААР БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 06 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
С.Батболд**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2015 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хороо 2015 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хийж, дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хорооны хуралдаанаар хийх үед Улсын Их Хурлын гишүүн С.Батболд, Д.Арвин, Г.Баярсайхан, О.Баасанхүү, С.Оюун нар төсөл санаачлагчаас асуулж, тайлбар, тодруулга авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол тус бүрээр санал хураалгасан болно.

Улсын Их Хурлын гишүүн С.Батболд төслийн 2 дугаар зүйлийн “16.1.15-16.1.18” гэсэн нь техникийн алдаа тул “16.1.5-16.1.8” гэж өөрчлөх, “үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт” гэснийг “улс, бус нутгийн хэмжээний бүтээн байгуулалт” гэж өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн С.Оюун төслийн 1 дүгээр зүйлд “аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар” гэж нэмэх, энэ саналтай нийцүүлээд Засгийн газарт аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах эрхийг нь нээх гэсэн зарчмын зөрүүтэй саналыг тус тус гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн С.Оюуны гаргасан “төсөлд үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газрын жагсаалтыг Улсын Их Хурал батална.” гэж нэмэх гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул тэрээр энэ асуудлаар цөөнх болов.

Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гарсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

С.БАТБОЛД

УХА0316

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт

**“ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Нэг. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

1. Төслийн 2 дугаар зүйлийн “16.1.15-16.1.18” гэснийг “16.1.5-16.1.8” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд

2. Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 16.1.14 дэх заалт нэмэх:

“16.1.14.аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Оюун

3. Дээрх саналтай нийуүлээд төслийн 2 дугаар зүйлд “16.1.13” гэсний дараа “16.1.14” гэж нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Оюун

4. Төслийн 1 дүгээр зүйлийн “үндэсний хэмжээний томоохон” гэснийг “улс, бүс нутгийн хэмжээний” гэж өөрчлөх

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Батболд

Хоёр. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжээгүй санал:

1. Төслийн 2 дугаар зүйлд “16.1.13-д заасан газрын жагсаалтыг Улсын Их Хурал батална гэж нэмэх”.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Оюун
Цөөнх: Улсын Их Хурлын гишүүн С.Оюун

ооо